

ШУТИС-ийн оюутны мэргэжлийн болон сайн дурын клубүүдийн нэгдсэн өдөрлөг боллоо.

ШУТИС-ийн оюутны мэргэжлийн болон сайн дурын клубүүдийн нээлттэй өдөрлөг оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид заасан төлөвлөгөөний дагуу 2016 оны 09 сарын 26-нд 11:00-16:00 цагийн хооронд хичээлийн байруудад зохион байгуулагдлаа. Тус өдөрлөгт нийт 24 клубүүд үйл ажиллагаагаа явуулж оролцов.



Мэргэжлийн клубүүдээс


- ГУУС- ийн “Хөгжлийн ирээдүй” мэргэжлийн клуб
- YTC- ийн “ProArte”, “WHIZZ” “Flair”, “D Art”, “IB” мэргэжлийн клубүүд
- МХТС-нь оюутны зөвлөл-клубүүдийн нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулж “High-tech”, “Sys&Cotech”, “UC” англи хэлний клубүүд
- ГХИ-ийн “Звёздочка” мэргэжлийн клуб





Сайн дурын клубүүдээс

“Мэргэн шагайн харваа”, “Хөгжлийн жигүүр”, “Хөтлөгчийн клуб”, “Багшийн туслах оюутан”, “Профессорын туслах оюутан” “AIESEC-MUST”, “Empowerment” мэтгэлцээний клуб, “Хос уянга” цэнгээнт бүжгийн клуб, “Судлаач оюутан”, “Хятад хэлний”, “Герман хэлний-Meine Zukunft”, “Тэмүүлэл” спорт аялалын клубүүд оролцлоо.



Тус өдөрлөгийн үеэр клубүүдийн оюутнууд мэндчигээ дэвшүүлж урлагийн тоглолт, жүжигчилсэн дуулалт үзүүлбэр зэргийг бэлтгэн ирж оролцоо. Клубүүдүүдэд нийт 340 оюутан шинэ гишүүнээр бүртгүүлж олон оюутан сонирхсон үр дүнтэй ажил боллоо.

Энэ жилээс шинээр нээгдсэн “Профессорын туслах оюутан” клуб нийт 40 гишүүн бүртгүүлэн элсэж, зарим багш нар хамтран ажиллахаар санал өгсөн байна. Мөн зарим нэг клубүүд байгуулагдах саналууд ирсэн.

Үйл ажиллагааг хөтлөгчийн клубийн ахлагч Б.Мөнх-Эрдэнэ хөтлөж, зохион байгуулалтанд ОХУА, Багшийн туслах оюутан клубийн ахлагч Э.Энхмандах, идэвхтэн оюутан Ө.Маралмаа, П.Батбаяр нар ажилласан.



ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА